

НЭГ БҮРИЙН ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ ХЭРЭГЛЭХ ҮНДЭСЛЭЛ ЖУРАМ ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Ширэндэвийн Чулуун

ХСИС-н Цагдаагийн сургуулийн, цагдаагийн эрх зүйн
тэнхимийн ахлах багш, магистр, цагдаагийн хошууч

Цагдаагийн байгууллага, алба хаагч нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэхдээ Цагдаагийн байгууллагын тухай хуульд заасны дагуу дараах төрлийн тусгай хэрэгсэл, мэх ашиглана гэж заажээ.¹ Үүнд:

- 1/ Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл
- 2/ Нэг бүрийн тусгай хэрэгсэл
- 3/ Тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл
- 4/ Хамгаалах тусгай хэрэгсэл
- 5/ Самбо, каратэ зэрэг зэвсэггүйгээр тулалдах мэх
- 6/ Албаны нохой

Цагдаагийн албанд ашиглах нэг бүрийн тусгай хэрэгслийн төрлүүд, түүнийг алба хаагчаас хэрэглэх эрх болон үндэслэлийг нь Цагдаагийн байгууллагын тухай хуулинд дараах байдлаар хуульчлан тусгасан байна.²

Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 5-р бүлгийн 43 дугаар зүйлд зааснаар:

1. Нэг хүнд нөлөөлөх хэрэгслийг нэг бүрийн тусгай хэрэгсэл гэнэ.
2. Нэг бүрийн тусгай хэрэгсэлд дараахь хэрэгсэл хамаарна.

- 1/ гар, хөл, хурууны гав
- 2/ хүлэг, ороох цамц
- 3/ резинэн бороохой
- 4/ цахилгаан бороохой
- 5/ нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр
- 6/ резинэн ба хуванцар сумтай буу

3. Цагдаагийн алба хаагч дараахь тохиолдолд нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрэглэж болно

1/ цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг зориуд биелүүлээгүй, эсхүл эсэргүүцсэн

- 2/ сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг хуяглан хүргэх

3/ цагдаагийн алба хаагчийн амь нас, эрүүл мэндэд аюултайгаар эсэргүүцэж болох сэжигтэн, яллагдагч, ялтанг баривчлах

4/ Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 42 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан тохиолдолд

4. Дараахь тохиолдолд хүлэг буюу ороох цамц хэрэглэж болно.

- 1/ сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан амиа хорлож болзошгүй бол

2/ сэтгэл мэдрэлийн өвчний улмаас өөрийгөө жолоодох чадвараа алдсан буюу согтуу этгээд догшин хэрцгий авирлаж бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулахаар бол.

5. Энэ зүйлийн 4 дэх хэсгийн 2-т заасан тохиолдолд уул этгээдэд хүлэг, ороох цамц хэрэглэж болох эсэх тухай эмнэлгийн магадлагаа урьдчилан гаргуулах буюу, эсхүл эмч байлцуулна.

Галт зэвсэг, бүх төрлийн тусгай хэрэгсэл хэрэглэх зааврыг улсын ерөнхий прокурортой зөвшилцөн цагдаагийн төв байгууллагын дарга батлана.³

Мөн цагдаагийн алба хаагчаас хуулинд заасан үндэслэл бүхий нөхцөл бий болсон тохиолдолд тусгай хэрэгслийг хэрэглэх бөгөөд энэ эрхээ хэрэгжүүлэхдээ тухайн алба хаагчаас тусгай хэрэгслийг зөв хуулийн хүрээнд хэрэглэх, эрхээ хэтрүүлэхгүй байлгах зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын даргын 1994.03.31-ний өдрийн 75-р тоот тушаалын 1-р хавсралтаар батлагдсан "Цагдаагийн тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх заавар"-ыг цагдаагийн байгууллага, алба хаагч нь үйл ажиллагаандаа ашиглан ирсэн ба улмаар

¹ Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 5-р бүлгийн 41.1 хэсэг

² Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 5-р бүлгийн 43-р зүйл

³ Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 5-р бүлгийн 45-р зүйлийн 1 дэх хэсэг

цагдаагийн албанд мөрдөгдөх журам /стандарт/-ыг боловсронгуй болгох ажлын хүрээнд 2010.04.02-ны өдөр Цагдаагийн ерөнхий газрын дарга Монгол улсын ерөнхий прокурортой зөвшилцөн баталсан 173-р тоот тушаалын 1-р хавсралтанд шинэчлэн боловсруулж түүндээ "Нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх заавар"-ыг тусган өгсөн.

Мөн нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрэглэх нийтлэг арга хэлбэр, дэг горимыг тодорхойлж өгсөн байна.Үүнд:

Цагдаагийн байгууллага, алба хаагч хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу зэвсэггүйгээр тулалдах мэх, **тусгай хэрэгсэл**, галт зэвсэг хэрэглэхэд дараах нийтлэг журмыг баримтална.

а/Бололцоотой бүх тохиолдолд галт зэвсэг, олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх тухайгаа урьдчилан сануулах

б/Тухайн нөхцөл байдалд хамгийн бага хохирол учруулахыг эрмэлзэх

в/Хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан бол эмнэлгийн байгууллагад мэдэгдэж, эрүүл мэндийн анхан шатны туслалцаа үзүүлэн захирах даргадаа илтгэн дарга нь прокурорт бичгээр мэдэгдэх Цагдаагийн алба хаагч нь албан үүрэг гүйцэтгэлийн онцлогоос хамааралтайгаар нэг бүрийн тусгай хэрэгсэл эрхийг нь дараах байдлаар ялгамжтай зааглаж өгсөн байна. Үүнд:

- Жагсаал, цуглааныг албадан тараах, нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтын үед Цагдаагийн төв байгууллагын даргын шийдвэрээр байгуулсан Шуурхай удирдлагын штаб /Цаашид “Удирдлагын штаб” гэнэ/-ын даргын зөвшөөрөлгүй галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэхийг хориглоно.
- Дээр дурдсан үндэслэлүүдээс бусад тохиолдолд галт зэвсэг, нэг бүрийн тусгай хэрэгсэл, зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэх шийдвэрийг цагдаагийн алба хаагч өөрөө гаргана.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код 235-д цагдаагийн алба хаагч нь гавыг дор дурдсан тохиолдолд заавал хэрэглэнэ гэж тусгаж өгсөн байна.

а/Нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох

б/Нийгмийн хэв журмыг бүлэглэн зөрчиж байгааг таслан зогсоох

в/Хориглон эсэргүүцэж байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг баривчлах

г/Цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг зориуд биелүүлээгүй, эсхүл эсэргүүцсэн, амь нас, эрүүл мэндэд халдаж болзошгүй

д/Гэмт хэрэг, зөрчил үйлдсэнд сэрдэгдсэн хүн болон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг хүргэх, тээвэрлэх үед тус тус хэрэглэхээр заажээ.

Энэ нь алба хаагч өөрийн болон бусад хүмүүсийн аюулгүй байдлыг хангах мөн тухайн этгээдийн эсэргүүцлийг таслан зогсоох ач холбогдолтой юм. Гавтай этгээдийг авч явахдаа алба хаагч нь чанх урд нь ба ард нь явж болохгүй зөвхөн баруун талд нь юмуу зүүн талд нь эсвэл баруун хойно нь юмуу зүүн хойно нь явах, аль болох аль нэг гараас нь барьж авч явах хэрэгтэй.

Энэ нь тухайн этгээдийг бэртэж гэмтэх, амиа хорлохоос урьдчилан сэргийлэх зорилготой юм. Хүлгийг хүний гар, биед шигдэхээргүй, сунадаггүй, үрж гэмтэл учруулахгүй эдлэлээр хийнэ.

Өөрөөр хэлбэл нарийн мяндсан юмуу гар биед шигддэг, резинэн болон олсон төрлийн ширүүн материалтай уяа биш зөөлөн даавуун эдлэлтэй уяа байна. Дараах аргуудаар хүлгийг хэрэглэхээр зааварт тусгайлан зааж өгсөн байна.

а/Хүлэгний үзүүрт тооно тушиж, жижиг гогцоо гарган баруун зүүн гарынх нь бугуйгаар гогцоолдон, хагас тугавчилан уяж, гарыг ар нуруунд нь нугалан дээш нь татаж, хүлэгний үзүүрийг зүүн, баруун мөрөн дээгүүр давуулан мөрөвчлүүлж баруун зүүн суга доогуур гаргасны дараа зүүн баруун гарыг ар талд нь нугалан шуугаар нь бүтэн тугавчилан уяж, зүүн баруун далны маяа ясны орчимд мөрөвчилсөн хүлэгнээс гогдон эрхийвчилж, баруун /зүүн/ гарыг давхар давуулан аль нэг хөлийг ар дээш сойж хөврөхөөр зангидна. Энэ аргыг “дөрвөлжин хүлэг” гэнэ.

Дөрвөлжин хүлгийг тухайн этгээдэд хийхдээ алба хаагч аюулгүй байдлыг хангах үүднээс дээр дурдсан аргачлалаар зөвхөн хийнэ. Мөн дөрвөлжин хүлэг, ороох цамцыг шууд болон шаардлагатай тохиолдолд хэрэглэж болох эсэх тухай эмнэлгийн магадлагаа урьдчилан гаргуулах буюу, эсхүл эмч байлцуулна гэж Цагдаагийн байгууллагын тухай хуулинд тусгайлан заажээ.⁴

б/Хоёр гарыг урд нь ба ард нь болон хөлийг зөөлөн эдээр холбон тугавчилж үзүүрийг хөврөхөөр уяж, хоёр гарыг бугуйгаар, эсхүл эрхий хуруунуудыг холбон хүлнэ. Энэ үед хүлгийг уг этгээд өөрөө тайлах

⁴ Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 5-р бүлгийн 43-р зүйлийн 4,5 дахь заалт

боломжтой эсэхийг анхаарна. Өөрөөр хэлбэл 2 гарыг зөвхөн бугуйн хэсгээр урд нь ба ард нь холбох эсвэл эрхий хурууг хооронд нь 1 ба 2-р үений дунд хэсгээр урд нь ба ард нь холбон хүлнэ.

в/Шаардлагатай бол сандал дээр даруулах болон багана зэрэг зүйлтэй холбож хүлж болно. Энэ үед холбож хүлсэн зүйл нь унаж дарагдах, цохигдохоос сэрэмжилсэн байна. Тухайн холбон хүлсэн зүйл нь тухайн этгээдийн амь нас, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байвал зохино.

Ороох цамцыг даавуун эдлэлээр 2 м урт ханцуйтай хийнэ.

Ороох цамцыг хүний урд талаас өмсгөж, арын гурван бүчийг хөврөхөөр уяж, ханцуйтай гарыг урд нь зөрүүлэн, ханцуйг хоёр суган доогуур оруулан ар тийш татаж, нуруун дээр нь зөрүүлэн урагш эргүүлэн хоёр гарын булчинг даруулах ба суган доогуур оруулан ар тийш татаж, нуруун дээр нь зөрүүлээд урагш эргүүлэн хоёр гарын булчинг даруулан, суган доогуур оруулж үзүүрийг зөрүүлэн буцааж ар нуруунд хөврөхөөр уяна гэж зааварт тусгасан байна.⁵

Ороох цамцыг хэрэглэсэн тохиолдолд харгалзан хянаж байгаа алба хаагч өөрийн хяналтандаа байлгах шаардлагатай. Учир нь тухайн этгээдийн хөдөлгөөн хэдийгээр хязгаарлагдсан ч бүрэн гүйцэд хязгаарлагдаагүйн улмаас амиа хорлох, эрүүл мэндээрээ хохирох нөхцөл бүрдэх тул аюулгүй байдлыг сахин ажиллах нь зайлшгүй шаардлагатай юм.

Ороох цамц, дөрвөлжин хүлэгтэй хүний амьсгалыг дарж, гэдсийг хүлэг ороогоогүй байгаа эсэхийг шалгаж, байнгын хяналтад байлгаж 30 минутаас илүү хугацаагаар хэрэглэж болохгүй ба шаардлагатай бол өөр тусгай хэрэгсэл хэрэглэнэ. Энэ нь алба хаагч эрхээ хэтрүүлэхгүй өөрөөр хэлбэл ороох цамц, дөрвөлжин хүлгийг хэрэглэх хамгийн дээд хэмжээг 30 минут байхаар тусгасан байна. Тухайн этгээдэд ороох цамц, дөрвөлжин хүлгийг 30 минут хэрэглэсэн ч эсэргүүцэл нь таслан зогсоогдоогүй бол өөр тусгай хэрэгсэлтэй ээлжлэн хэрэглэхийг нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх зааварт зааж өгсөн байна. Насанд хүрээгүй, өндөр настай, тахир дутуу болон эмэгтэй хүнд дөрвөлжин хүлэг хэрэглэхийг хориглоно гэж тодорхой субъектүүдийг онцгойлон тусгажээ.⁶

Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч бодисыг дараах нэр томъёогоор тодорхойлж өгсөн байна.⁷ Үүнд:

“Нулимс асгаруулагч” –Хамрын самсаа болон нулимсны булчирхайг цочроож нулимс ихээр гоожуулах хий, шингэн төлөв байдалтай бодис /гар бөмбөг, сум, утаа, шүршүүр хэлбэртэй байж болно.

“Амьсгал боогдуулагч”– Амьсгалын замын эрхтнээр дамжин уушгинд хүрч ханиалгах, амьсгал, хоолой боох үйлчлэл үзүүлэх зориулалт бүхий шингэн болон хийн төлөв байдалтай бодис нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчийн үйлчлэл нөлөөлсөн хүний эсэргүүцэл, довтолгоо зогссон тохиолдолд түүнд тусгай хэрэгслийн үйлчилгээг саармагжуулах боломж олгоно.

Өөрөөр хэлбэл тухайн этгээд эсэргүүцэл үзүүлэх чадваргүй болсон үед та өөрийн болон орчны аюулгүй байдлыг сахин хамгаалсаны дараа түүнд нүүр гараа угааж арчих, цэвэрлэх боломжийг олгосон байна. Мөн хийн буугаа цэвэрлэх боломжгүй тохиолдолд битүү сав юм уу гялгар уутанд хийж амыг нь сайн зангидсан байна.

Битүү өрөө тасалгаанд хийн буугаар буудсан тохиолдолд тухайн өрөө тасалгааг түргэн орхин гарч аль болох цонх хаалгыг онгойлгон агаарын солилцоо хийлгүүлэн хэвийн болгох арга хэмжээг авбал зохино. Агаарын солилцоо муу орчинтой тухайн өрөө тасалгаанд сэнс залгаж агаарын солилцоог сайжруулж болно. Гадаа задгай талбайд хийн буугаар буудлага хийхдээ алба хаагч салхины чигийг сайтар анхаарч салхины дээд талаас нь буудахыг анхаарах хэрэгтэй.

Тухайн этгээдийн гаргасан хэрэг, зөрчлийн байдлаас шалтгаалж түүнд ямар төрлийн хийн бууны сумыг хэрэглэвэл илүү үр дүнтэй болохыг тооцон буудлага үйлдэх нь нэг талаас цагдаагийн алба хаагчийн ур чадварыг харуулахаас гадна нөгөө талаас тухайн этгээд нь гэмт хэрэг зөрчил үйлдсэн хэдий боловч түүнд аль болох бага хохирол учруулах явдал юм.

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн, нийгмийн хэв журмыг бүлэглэн зөрчиж довтолсон тохиолдолд бороохойгоор хүний толгой, давсаг, бүсэлхий, бөөрний тус газарт цохихыг зөвшөөрсөн заалтыг тус зааварт тусгаж өгсөн нь алба хаагчийн албан үүргээ гүйцэтгэх нөхцлийг бүрдүүлснээрээ ач холбогдолтой юм.

⁵ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 2010 оны 04 дүгээр сарын 02 –ны өдрийн 173 тоот тушаалын 1-р хавсралт код- 235.6.1 дэх заалт Нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх заавар

⁶ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 2010 оны 04 дүгээр сарын 02 –ны өдрийн 173 тоот тушаалын 1-р хавсралт код- 235.6.3 дах заалт Нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх заавар

⁷ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 2010 оны 04 дүгээр сарын 02 –ны өдрийн 173 тоот тушаалын 1-р хавсралт код- 233.3.2 Галт зэвсэг, тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх заавар

Дээр дурдсан тохиолдлоос бусад нөхцөлд хүний биеийн дээрхи нэрлэгдсэн хэсгүүдэд бороохой хэрэглэхийг хатуу хориглоно. Өөрөөр хэлбэл цагдаагийн алба хаагчийн бороохой хэрэглэх үндэслэлийг үүрэг гүйцэтгэх орчин нөхцлийг харгалзан ялгамжтай байдлаар тодорхойлжээ.

Мөн ЦБҮАЖ-ын код 235-д зааснаар Резинэн, хуванцар, үрлэн сумтай бууг алба хаагч нь гал хамгаалагчийг нь түгжиж биедээ авч явна. Алба хаагч үүрэг гүйцэтгэхийн өмнө резинэн, хуванцар сумтай бууны хэвийн ажиллагаа, аюулгүй байдлыг шалгаж, тавьж олгосон сумаар цэнэглэгдсэн эсэхийг шалгасан байна. Мөн тус буугаар буудлага үйлдэх алба хаагч нь орчноо сайтар үнэлсэн байна. Жишээ нь: Өрөө тасалгаанд буудлага үйлдэхэд сум хананд ойж бусад хүнд гэмтэл учруулах гэх мэт.

Резинэн, хуванцар, үрлэн сумтай буутай харьцах алба хаагч нь тусгай сургалтанд хамрагдаж үүрэг гүйцэтгэх чадварыг эзэмшсэн байвал зохино.

Дээр дурдсантай уялдуулан дараах саналыг дэвшүүлж байна.

- Цагдаагийн байгууллага, алба хаагч гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэхдээ Цагдаагийн төв байгууллагын даргын шийдвэрээр албаны зэвсэглэмжид хүлээн авч бүртгэсэн галт зэвсэг, тусгай хэрэгсэл, сумыг хэрэглэнэ гэж заасан байдаг тул зөвхөн албанаас тавьж олгосон тусгай хэрэгслийг хуулийн хүрээнд зөв хэрэглэх нь эргээд алба хаагч аливаа хууль бус асуудалд орохгүй албан үүргээ хэвийн гүйцэтгэх нөхцөл бүрдэх юм. Өөрөөр хэлбэл та хэдийгээр цагдаагийн алба хаагч байсан ч албаны зэвсэглэмжинд бүргэгдээгүй тусгай хэрэгслийг хуулинд заасан үндэслэл бүхий нөхцөлд тухайн этгээдэд хэрэглэсэн ч эргээд таны гаргасан үйлдэл буруу тул анхаарах хэрэгтэй юм.
- Галт зэвсэг, тусгай хэрэгслийг хууль тогтоомжид заасан журам, заавар болон үйлдвэрлэгчээс гаргасан зааврын дагуу хэрэглэх бөгөөд үйлдвэрлэгчийн зааврыг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын хавсралт болгож хэрэглэнэ. Тусгай хэрэгслийн үйлдвэрлэгчээс гаргасан заавар нь гадаад хэл дээр бол хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан орчуулагчаар албан ёсны орчуулгыг хийлгэнэ гэж зааварт заасан тул цагдаагийн газар хэлтэс, тасаг, хэсгүүдэд тусгай хэрэгслийг албанаас тавьж олгохдоо монгол хэл дээр хөрвүүлсэн үйлдвэрлэгчийн зааврыг хамт олгох шаардлагатай байна. Энэ нь тухайн тусгай хэрэгслийг хүлээн авсан алба хаагч тусгай хэрэгсэлтэйгээ зөв харьцах, аюулгүй ажиллагааг сахин хамгаалахад онцгой ач холбогдолтой юм.
- Цагдаагийн төв байгууллага нь цагдаагийн байгууллага, алба хаагчийг нэг бүрийн хамгаалах болон бусад тусгай хэрэгслээр хангах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ. Бүх төрлийн тусгай хэрэгслийн ашиглалтын албаны бэлэн байдалд Цагдаагийн төв байгууллагын нийгмийн хэв журам хамгаалах алба хяналт тавина гэж заасан тул төв орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн алба хаагчдыг шаардлагатай тусгай хэрэгслээр хангаснаар албан үүргээ хэвийн гүйцэтгэх, алба хаагч өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг сахин хамгаалах ач холбогдолтой юм.
- Цагдаагийн байгууллагын дарга гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах үүрэгтэй алба хаагчдыг тусгай хэрэгсэл хэрэглэх сургалтад хамруулж байна. Цагдаагийн төв байгууллагаас баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу хамгаалах болон нэг бүрийн тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх сургалтыг улиралд нэгээс доошгүй удаа зохион байгуулна гэж зааварт заасан тул цагдаагийн газар, хэлтсүүдийн сургалт хариуцсан ажилтан алба хаагчдынхаа дунд сургалтыг тогтмол хугацаанд чанартай үр дүнтэй зохион явуулснаар алба хаагчдын тусгай хэрэгсэл хэрэглэх мэдлэг, ур чадвар сайжрах нөхцөл бүрдэх юм.